



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/89/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Манаргүл Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (975) 7043-2054
E-mail: bayanuljin@audit.gov.mn

**ТОЛБО СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ДАУЛЕТ ТАНАА**

᠒᠐21-᠐᠗.᠑᠕ № ᠒4᠐
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүг эг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>146,304,254.71</u>	<u>153,864,496.71</u>
33	АВЛАГА	2,290,300.00	394,172.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		394,172.00
335	Бусад авлага	2,290,300.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,290,300.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	144,013,954.71	153,470,324.71
354	Хангамжийн материал	132,161,954.71	138,852,824.71
35420	Аж ахуйн материал	127,237,754.71	138,692,824.71
35440	Түлш, шатах тослох материал	480,000.00	160,000.00
35460	Хүнсний материал	4,444,200.00	-
35600	Мал амьтад	11,852,000.00	14,617,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,885,516,015.24</u>	<u>1,919,155,634.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,885,516,015.24	1,919,155,634.15
392	Биет хөрөнгө	1,879,284,015.24	1,912,923,634.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,866,441,926.20	1,911,464,558.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,661,842.21)	(142,574,888.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,256,208.25	212,185,208.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(172,701,505.49)	(176,259,108.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,232,154.73	167,966,354.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(90,702,315.24)	(109,099,380.80)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,200,000.00	1,200,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,583,935.00	2,583,935.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,583,935.00)	(2,583,935.00)
39217	Ном	46,219,389.00	48,040,891.00
393	Биет бус хөрөнгө	6,232,000.00	6,232,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,782,000.00	6,782,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,031,820,269.95</u>	<u>2,073,020,130.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,313,494.00</u>	<u>2,593,820.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,313,494.00	2,593,820.00
413	Өглөг	1,313,494.00	2,593,820.00
4136	Бусад өглөг	1,313,494.00	2,593,820.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,313,494.00	2,593,820.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,030,506,775.95</u>	<u>2,070,426,310.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,030,506,775.95	2,070,426,310.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,415,384,459.00	1,415,384,459.00
51101	Өмч: - төрийн	1,415,384,459.00	1,415,384,459.00
512	Хуримтлагдсан үр дүн	(694,316,128.89)	(654,396,593.98)

51210	Өмнөх үеийн үр дүн	(694,316,128.89)	(694,316,128.89)
51220	Тайлант үеийн үр дүн	-	39,919,534.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,309,438,445.84	1,309,438,445.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,031,820,269.95	2,073,020,130.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,855,410,824.63	1,890,883,205.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,905,441.91	18,892,847.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,905,441.91	18,892,847.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	24,905,441.91	18,892,847.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,905,441.91	18,892,847.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,830,505,382.72	1,871,990,358.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,656,532,682.72	1,695,779,134.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	125,288,382.72	94,097,334.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,531,244,300.00	1,601,681,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,003,224.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,003,224.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	173,972,700.00	167,208,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,972,700.00	167,208,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,801,841,200.86	1,850,963,670.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,801,841,200.86	1,850,963,670.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,730,559,510.86	1,805,294,120.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,234,086,398.00	1,282,362,800.00
210101	Үндсэн цалин	1,123,838,198.00	1,210,803,400.00
210104	Урамшуулал	110,248,200.00	71,559,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,454,613.00	172,604,928.00
210201	Тэтгэврийн даатгал	122,315,413.00	121,430,328.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,034,800.00	12,793,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,627,800.00	10,234,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,407,000.00	2,558,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,069,600.00	25,587,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,239,780.00	168,736,430.00
210301	Гэрэл, цахилгаан	3,236,880.00	7,809,930.00
210302	Түлш, халаалт	165,484,900.00	160,371,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,518,000.00	555,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,595,094.00	20,368,147.00
210401	Бичиг хэрэг	1,517,900.00	3,912,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,199,994.00	4,280,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	870,000.00	1,770,400.00

210404	Ном, хэвлэл	-	502,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,660,000.00	570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,347,200.00	9,331,997.00
2105	Нормативт зардал	49,778,230.00	87,696,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	408,000.00	484,700.00
210502	Хоол, хүнс	48,108,930.00	83,752,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,261,300.00	3,459,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	420,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	420,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	838,000.00	920,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,000.00	320,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,147,395.86	71,465,315.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,050,000.00	1,674,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,980,500.00	3,923,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,116,895.86	65,867,715.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,281,690.00	45,669,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,879,600.00	38,193,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,879,600.00	38,193,330.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,939,470.00	7,378,850.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,939,470.00	7,378,850.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	462,620.00	97,370.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	462,620.00	97,370.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>53,569,623.77</u>	<u>39,919,534.91</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>53,569,623.77</u>	<u>39,919,534.91</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(694,316,128.89)	2,030,506,775.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(694,316,128.89)	2,030,506,775.95
D08	Тайлант үеийн үр дүн			39,919,534.91	39,919,534.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,415,384,459.00	1,309,438,445.84	(654,396,593.98)	2,070,426,310.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,705,217,000.00</u>	<u>1,777,893,024.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,705,217,000.00	1,777,893,024.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,531,244,300.00	1,601,681,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,531,244,300.00	1,601,681,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,003,224.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,003,224.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	173,972,700.00	167,208,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,972,700.00	167,208,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,704,889,000.00</u>	<u>1,772,483,024.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,704,889,000.00	1,772,483,024.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,633,607,310.00	1,726,563,474.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,229,997,700.00	1,282,362,800.00
210101	Үндсэн цалин	1,119,749,500.00	1,210,803,400.00
210104	Урамшуулал	110,248,200.00	71,559,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,469,600.00	172,999,100.00
210201	Тэтгэврийн даатгал	114,330,400.00	121,824,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,034,800.00	12,793,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,627,800.00	10,234,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,407,000.00	2,558,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,069,600.00	25,587,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,510,080.00	166,110,630.00
210301	Гэрэл, цахилгаан	3,936,880.00	7,809,930.00
210302	Түлш, халаалт	168,055,200.00	157,760,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,518,000.00	540,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,686,200.00	13,843,844.00
210401	Бичиг хэрэг	1,199,900.00	3,498,424.00
210402	Тээвэр, шатахуун	1,886,500.00	2,142,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	870,000.00	1,770,400.00
210404	Ном, хэвлэл		502,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,660,000.00	570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,069,800.00	5,359,720.00
2105	Нормативт зардал	53,282,730.00	83,882,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	408,000.00	484,700.00
210502	Хоол, хүнс	48,108,930.00	79,308,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,765,800.00	4,089,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,000,000.00

2107	Томилолт, зочны зардал	420,000.00	446,000.00
210702	Дотоод албан томилолт	420,000.00	446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	838,000.00	1,157,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,000.00	557,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,403,000.00	4,761,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,403,000.00	4,761,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,281,690.00	45,919,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,879,600.00	38,443,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,879,600.00	38,443,330.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,939,470.00	7,378,850.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,939,470.00	7,378,850.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	462,620.00	97,370.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	462,620.00	97,370.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	328,000.00	5,410,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	328,000.00	5,410,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	328,000.00	5,410,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	328,000.00	5,410,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	328,000.00	5,410,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(328,000.00)	(5,410,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,768,889,800.00	1,761,413,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,768,889,800.00	1,761,413,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,730,439,300.00	1,722,970,250.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,282,362,800.00	1,282,362,800.00
210101	Үндсэн цалин	1,210,803,400.00	1,210,803,400.00
210104	Урамшуулал	71,559,400.00	71,559,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,119,100.00	172,999,100.00

210201	Тэтгэврийн даатгал	121,824,500.00	121,824,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,823,700.00	12,793,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,258,900.00	10,234,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,564,700.00	2,558,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,647,300.00	25,587,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,208,000.00	166,110,630.00
210301	Гэрэл, цахилгаан	7,377,000.00	7,809,930.00
210302	Түлш, халаалт	158,291,000.00	157,760,700.00
210303	Цэвэр, бохир ус	540,000.00	540,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,996,000.00	7,995,620.00
210401	Бичиг хэрэг	390,200.00	390,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,142,800.00	2,142,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,400.00	1,420,400.00
210404	Ном, хэвлэл	557,500.00	557,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,485,100.00	3,484,720.00
2105	Нормативт зардал	93,233,600.00	85,982,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	484,700.00	484,700.00
210502	Хоол, хүнс	88,659,300.00	81,408,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,089,600.00	4,089,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	446,000.00	446,000.00
210702	Дотоод албан томилолт	446,000.00	446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,157,500.00	1,157,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	557,500.00	557,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,916,300.00	4,916,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,916,300.00	4,916,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,450,500.00	38,443,330.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,450,500.00	38,443,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,450,500.00	38,443,330.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,768,889,800.00	1,761,413,580.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,601,681,800.00	1,594,302,950.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,601,681,800.00	1,594,302,950.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	167,208,000.00	167,110,630.00
132001	Орон нутгийн төсвөөс	167,208,000.00	167,110,630.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110.00	110.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	69.00	69.00
620003	Үйлчлэх ажилтан	40.00	40.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	110.00	110.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	69.00	69.00

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	41.00	41.00
--------	--	-------	-------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	9,003,224.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	9,003,224.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	9,003,224.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	7,748,224.00
210401	Бичиг хэрэг		3,108,224.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		350,000.00
210404	Ном, хэвлэл		245,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		570,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,475,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,255,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,255,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго: “Хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- Багш, ажилчдын ажлын хариуцлагыг чангатгаж хууль дүрмийн дагуу хариуцлага тооцох.
- Сургалтын хоцрогдлыг арилгах тусгай төлөвлөгөө гаргаж, сургалтын чанарт ахиц гаргах
- Сонгон судлах хичээлийг чанартай зохион байгуулж ЭЕШ-ын дүнгээр 2 байраар урагшлуулах.
- Дотуур байрны сурагчдад тавих хараа хяналтыг сайжруулах, мэргэжлийн багш нар болон эцэг эх, асран хамгаалагчтай нь хамтран ажиллах.
- Багш ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх.
- Цахим хичээл зохион байгуулах орчин бүрдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдыг нь татан оролцуулах, хамтран ажиллах.
- Сургууль завсардахаас сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовнил, стрессгүйгээр суралцах, хөгжихэд дэмжлэг үзүүлэх эрүүл, аюулгүй амьдрах зөв дадал хэвшүүлэх.
- Багш нарын арга зүйг дээшлүүлэх

Тус сургууль нь хүүхдүүдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол мөн насан туршийн боловсрол эзэмшүүлдэг чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулж шалгалт хийсэн байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1801.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41.2 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,290.3	394.2	(1,896.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	144,014.0	153,470.3	9,456.4
Үндсэн хөрөнгө	1,885,516.0	1,919,155.6	33,639.6
Нийт хөрөнгө	2,031,820.3	2,073,020.1	41,199.9
Өр төлбөр	1,313.5	2,593.8	1,280.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,030,506.8	2,070,426.3	39,919.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,031,820.3	2,073,020.1	41,199.9

Оны эхэн ба эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй гарсан байна.

Авлага 0.4 сая төгрөг болж оны эхнээс 1.9 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 153.5 сая төгрөг болж 9.5 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 136.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн ОНХСангаас 9.3 сая төгрөгийн зөөлөн эдлэл, аймгийн боловсролын газраас 0.9 сая төгрөгийн ариутгалын бодис, сумын Сум хөгжүүлэх сангаас сургуулийн тусгаарлах байрны хангамжид 4.0 сая төгрөг, Малын нас дэвшилт болон төлийн орлогоос 4.4 сая төгрөгийн бүгд, 18.9 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч 144.3 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаанд зарцуулж, мал амьтадаас бусад зардалд 1.2 сая зарцуулан, Толбо сумын малын эмчийн тодорхойлолтоор 0.5 сая төгрөгийн малыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Аж ахуйн материал 138.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа материалын дансны нийт үлдэгдлийг 90.3 хувийг эзэлж байгаа ба ашиглах боломжгүй хугацаа нь дууссан 11.6 сая төгрөгийн химийн лаборантын химийн бодис, бусад хэрэглэгдхүүн бүртгэлд тусгагдсан байна.

Үндсэн хөрөнгө 33.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Дэлхийн банкны төслөөр 45.0 сая төгрөгийн дотуур байрны урсгал засвар, Боловсрол Шинжлэх Ухааны яамны хөрөнгө оруулалтаар 39.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, аймгийн ОНХСангаас 8.4 сая төгрөгийн тавилга, аймгийн Боловсролын газраас 1.5 сая төгрөгийн ном, бүгд 94.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгөнд 65.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Өглөг дансны үлдэгдэл 2.6 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр өссөн ба байгууллагад өгөх өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2070.4 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 39.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийг анх 1666.9 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1768.9 сая төгрөг болгон 102.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Үүнд цалин хөлс болон нэмэгдэл, урамшил 190.6 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 25.7 сая, хангамж, бараа материалын зардал 2.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нормативт зардлыг 106.0 сая, урсгал шилжүүлгийг 11.0 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосонтой холбоотой байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 119.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 25.7 сая төгрөгөөр дутуу суулгаж, урамшууллыг 71.5 сая төгрөгөөр төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1601.7 сая, орон нутгийн төсвөөс 167.2 сая, нийт 1768.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаанд 1761.4 сая төгрөг зарцуулж, 7.5 сая төгрөгийг хэмнэж, хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын 82.6 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 17.4 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дэлхийн банкны санхүүжилтээр Боловсрол шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинчлэл төслийн тэтгэлэгт хөтөлбөрийн 4 шат” -д шалгарсан төслөөс 8.0 сая төгрөгийг байгууллагын нэмэлт дансаар хүлээн авч, 8.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Мөн аймгийн Боловсролын газраас 0.6 сая төгрөгийн ариутгалын хөлст, элсэлтийн ерөнхий шалгалтын бичиг хэрэгт 0.4 сая төгрөг нэмэлт дансаар хүлээн авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардал, НДШ-ийн зардал, халаалтын зардал, хоолны зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зэрэг зардалд нийтдээ 1748.9 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зарлагаас үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 20.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 2.0 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба төсвөө 7.5 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна. Харин тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.4 сая төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авч Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 1777.9 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1777.9 сая төгрөгийн 117 мэдээллийг хугацаанд мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээллийг байршуулаагүй байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 254.4 сая төгрөгийн 15 гүйлгээ гарсныг мэдээлсэн, харин өр, авлага үүсгэсэн талаарх 2.9 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын дундаж 95.8 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар төлбөрийн 1 акт тогтоож, зөрчил арилгуулах 1 албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Харин цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж үндсэн болон нэмэлт дансны санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.4 сая төгрөгөөр шкаф худалдан авсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн

талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-д зааснаар “.....албан конторын тавилга, албан болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албан болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль	1	1.4					1	1.4		